



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ № 6

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2022 оны 02-р сарын 22 ноос 03-р сарын 07 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус БНХАУ, Энэтхэг, Канада, Грек, Филиппин, Литва, Бүгд Найрамдах Умард Македон, Польш зэрэг улс орны газар нутагт хүний болон нүүдлийн, тэжээвэр шувуудын дунд бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1 ээс харна уу).

ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2022 оны 02-р сарын 22 ноос 03-р сарын 07 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2022 оны 02-р сарын 22 ноос 03-р сарын 07 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусн хүний өвчлөлийн нийт 4 тохиолдол бүртгэгдсэн.

Бүх өвчтөн шувууны аж ахуйд ойр ажиллаж байсан ба 1 хүн нас барсан бусад хүний биеийн байдал одоогоор хүнд байна гэж Хонконгийн Эрүүл мэндийг хамгаалах төвөөс мэдээлсэн. Эхний тохиолдол нь Фужянь мужийн иргэн 46 настай эрэгтэйд 1-р сар-25 нд шинж тэмдэг илэрч 2-р сар-10 нд нас барсан. 2, 3 дахь тохиолдол нь Сичуан, Гуанси мужийн 48, 35 настай эрэгтэй хүмүүс байсан бол 4 дахь тохиолдол нь Жянсү мужийн 6 настай эмэгтэй хүүхэд 1-р сар-25 нд эмнэлэгт хандаж эмчлэгдэж байна. 2014 оноос хойш нийт БНХАУ-д 91, 2022 онд 9 тохиолдол бүртгэгдээд байна.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2022 оны 02-р сарын 22 ноос 03-р сарын 07 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H7N9 вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2022 оны 02-р сарын 22 ноос 03-р сарын 07 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H9N2 вирусн хүний өвчлөлийн шинэ 6 тохиолдол бүртгэгдсэн. Ихэвчлэн хүүхэд өртдөг ба шинж тэмдэг бага илэрдэг. 3 нь Анхуй, бусад нь Сичуан, Жянши, Хүбэй мужид бүртгэгдсэн.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2022 оны 02-р сарын 22 ноос 03-р сарын 07 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

ДОЛОО. Шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2022 оны 02-р сарын 22 ноос 03-р сарын 07 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

НАЙМ. Шувууны томуугийн А хүрээний (H10N3) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

Мөн хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H10N3) вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

ЕС. 2022 оны 02-р сарын 22 ноос 03-р сарын 07 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн хүний болон шувууны мэдээлэл (Хүснэгт 1):

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусын тархалт болон вирусын хэлбэр

№	Мэдээлсэн өдөр	Өвчилж эхэлсэн өдөр	Дэд хэвши нж	Улс	Муж, газрын нэр	Өртсөн нийт хүн, шувуудын тоо	Тайлбар
1	3/1/2022	1/10/2022	H9N2	БНХАУ	Жянши	1	Хүүхэд
2	3/1/2022	1/10/2022	H9N2	БНХАУ	Хүбэй	1	Хүүхэд
3	3/1/2022	1/10/2022	H9N2	БНХАУ	Сичуан	1	Хүүхэд
4	3/1/2022	1/10/2022	H9N2	БНХАУ	Анхуй	1	5 настай хүүхэд
5	3/3/2022	1/10/2022	H9N2	БНХАУ	Анхуй	1	51 настай эрэгтэй
6	3/3/2022	1/10/2022	H9N2	БНХАУ	Анхуй	1	5 настай хүүхэд
7	3/1/2022	1/25/2022	H5N6	БНХАУ	Сичуан	1	38 настай эрэгтэй
8	3/1/2022	1/25/2022	H5N6	БНХАУ	Фужянь	1	46 настай эрэгтэйд
9	3/1/2022	1/25/2022	H5N6	БНХАУ	Гуанси	1	48 настай эрэгтэй
10	3/1/2022	1/25/2022	H5N6	БНХАУ	Жянсү	1	6 настай эмэгтэй тхүүхэд
11	3/2/2022	2/2/2022	H5N1	Энэтхэг	Махараштра	28308	Тахиа
12	3/2/2022	2/10/2022	H5N1	Энэтхэг	Махараштра	518	Тахиа
13	3/2/2022	2/10/2022	H5N1	Энэтхэг	Махараштра	549	Тахиа
14	3/2/2022	2/5/2022	H5N1	Филлипин	Пампанга	78280	Бөднө, нугасны аж ахуй
15	3/2/2022	2/5/2022	H5N1	Голланд	Гелдерланд	47,000	Тахиа
16	3/1/2022	2/22/2022	H5N1	Литва	Каунас хот	2	Гунгар хун
17	3/1/2022	2/17/2022	H5N1	Бүгд Найрамдах Умард Македон Улс	Сэлсэ тосгон	1	Тураг гогой
18	3/3/2022	2/28/2022	H5N1	Канада	Принс Эдвардын Арал	1	Бүргэд
	3/6/2022	3/2/2022	H5N1	Грек	Микра-Преспа нуур	574	Хотон
	3/6/2022	2/28/2022	H5N1	Польш	Ровно	79	Тахиа

(Зураг 1) 2022 оны 02-р сарын 22 ноос 03-р сарын 07 ны хооронд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусын тохиолдлын тархалт, Монгол орныг дайран өнгөрөх нүүдлийн шувуудын томоохон замууд /зургаар/



АРАВ. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдолын мэдээлэл:

2022 оны 02-р сарын 22 ноос 03-р сарын 07 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.